
МЭДЭЭ · 2026 оны 3-р сарын 17

ӨНГӨРСӨН ДОЛОО ХОНОГТ 180,600 ЗӨРЧИЛ БҮРТГЭГДЖЭЭ



Прокурорын байгууллага 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл хугацаанд улсын хэмжээнд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны хүлээн авсан 180,600 зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн байна.

Үүнээс эрх бүхий албан тушаалтан 174,649 буюу 96.7 хувийг газар дээр нь, 1956 буюу 1.1 хувийг бүртгэлд авч хялбаршуулсан журмаар торгох шийтгэл оногдуулж, 1566 буюу 0.9 хувьд нь зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээжээ.

Прокурор эрх бүхий албан тушаалтны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн 1199 шийдвэрийг хянаж, 24 буюу 2 хувийг хүчингүй болгож, зөрчлийн хэрэг нээж зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлсэн байна.

Мөн эрх бүхий албан тушаалтны зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон 86 шийдвэрийг хянаж, 7 буюу 8.1 хувийг хүчингүй болгож, нэмэлт зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа хийлгэхээр буцааж, 1 буюу 1.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, 10 буюу 11.6 хувьд эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, шийдвэрлэн хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээжээ.

Зөрчлийн улмаас нийт 1,087,632,120 төгрөгийн хохирол учирснаас 250,209,261 буюу 23 хувийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад нөхөн төлүүлжээ.

Бүртгэгдсэн нийт зөрчлөөс Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих зөрчил 171,494 буюу 95 хувийг, Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах зөрчил 2313 буюу 1.3 хувийг, Автотээврийн тухай хууль зөрчих зөрчил 847 буюу 0.7 хувийг, Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих зөрчил 846 буюу 0.5 хувийг эзэлж байгаа нь хамгийн их байна.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/650